

Нэгдсэн Үндэстний Байгууллага



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ
ХҮНИЙ ЭРХИЙН ХОРОО

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮС, ТҮҮНИЙ
ДОТОР ХҮҮХДҮҮД ӨӨРСДИЙН ТӨЛӨӨЛЛИЙН
БАЙГУУЛЛАГААР ДАМЖУУЛАН КОНВЕНЦИЙН
ХЭРЭГЖИЛТ БА ХЯНАЛТАД ОРОЛЦОХ ТУХАЙ

ЕРӨНХИЙ ТАЙЛБАР-7

Улаанбаатар хот
2025 он



Орчуулгын санаачлагч:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй
эцэг эхчүүдийн холбоо

Монгол хэлэнд хөрвүүлсэн:

ХБХЭЭХолбооны зөвлөх Э.Цолмон

Орчуулга, хэвлэлийг санхүүжүүлэгч:

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй
3P4D ОРОЛЦОО тэтгэлэгт хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй
хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбооны
"Хамтын оролцоотой Хүртээмжтэй орон нутаг" төсөл.
400 хувь хэвлэв.

**FUNDING
WINDOWS**





ӨМНӨХ ҮГ

НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооноос гаргасан 2018 онд 7-р Ерөнхий тайлбарыг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоо нь өөрийн санаачлагаар Монгол хэлнээ анх удаа орчуулан, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Та бүхэндээ хүргэж буйдаа таатай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрэгчид алхам тутамдаа эрхээ эдэлдэг байх, нийгмийн бүхий л амьдралдаа бүрэн дүүрэн оролцоотой болгох олон улсын эрхзүй дэх эрхийн баталгаа бол НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц билээ. НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооноос найман Ерөнхий Тайлбарыг гаргасан билээ. НҮБ-ын Хүүхдийн сан анх 4р ерөнхий тайлбар "Тэгш хамран сургах эрхийн тухай Ерөнхий тайлбар 4-ийг орчуулан нийтэд түгээсэн юм.

Манай холбоо өмнө нь "Хүртээмж" – Ерөнхий тайлбар 2-ыг орчуулан олон нийтэд мэдлэг ойлголтыг түгээн, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж байна. Боловсролд тэгш хамран сургах болон Хүртээмжийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, саадгүй байдал хүртээмжийг бий болгоход хувь нэмрээ орууллаа. Энэ удаад Ерөнхий тайлбар 6, 7-г ХБХЭХолбоо орчуулан түгээж байгаадаа талархалтай байна.

Орчуулгын хувьд монгол хэлнээ тогтсон хэллэг байхгүй, оноосон орчуулга байхгүй байгаа нь ойлголтоо нэгтгэхэд хүндрэл учруулдаг. Орчуулга, найруулгатай холбоотой саналыг нээлттэй хүлээн авч, засан сайжруулах тул Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбооны info.apdcmongolia@gmail.com хаягаар бидэнтэй холбогдохыг хүсье.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй
эцэг эхчүүдийн холбоо

НҮБ-ЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ



4 дүгээр зүйл. Нийтлэг үүргүүд

3. Энэхүү конвенцийг хэрэгжүүлэхэд чиглэсэн хууль тогтоомж, бодлого хөтөлбөрийг боловсруулж мөрдөх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой бусад шийдвэрийг гаргахад оролцогч улс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй зөвлөлдөх бөгөөд тэднийг төлөөлөх байгууллагаар дамжуулан тэднийг идэвхтэй оролцуулна.

33 дугаар зүйл. Үндэсний түвшинд хэрэгжүүлэх болон хяналт тавих

3. Иргэний нийгмийн байгууллагууд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэднийг төлөөлөх байгууллагууд энэхүү хяналт тавих ажиллагаанд бүрэн дүүрэн оролцох, хамрагдах ёстой.





**Хөгжлийн бэрхшээлтэй
хүмүүсийн эрхийн тухай
конвенц**

Түгээлт: Ерөнхий
2018 оны Арваннэгдүгээр сарын 9
Эх хувь: Англи

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮС, ТҮҮНИЙ ДОТОР ХҮҮХДҮҮД, ӨӨРСДИЙН ТӨЛӨӨЛЛИЙН БАЙГУУЛЛАГААР ДАМЖУУЛАН КОНВЕНЦИЙН ХЭРЭГЖИЛТ БА ХЯНАЛТАД ОРОЛЦОХ ТУХАЙ ЕРӨНХИЙ ТАЙЛБАР №7 (2018)*

I. ОРШИЛ



1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн хэлэлцээ, боловсруулалт, батлах үйл явцад бүрэн оролцож, шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрийн төлөөллийн байгууллага болон түншлэлийнхээ оролцоотойгоор идэвхтэй, нягт зөвлөлдсөн нь Конвенцийн чанар, түүний хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбогдох ач холбогдолд эергээр нөлөөлсөн. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүч чадал, нөлөө, боломжийг харуулж, хүний эрхийн түүхэнд шинэ хуудас нээсэн, хөгжлийн бэрхшээлийн талаарх хүний эрхийн загварыг тогтоосон гэрээ бий болоход хүргэсэн. Иймд төлөөллийн байгууллагаараа дамжсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүрэн, утга учиртай оролцоо нь Конвенцийн цөм агуулга юм.
2. Хүн бүр өөрийн амьдрал, эрхэд нь нөлөөлөх шийдвэр гаргах үйл явцад¹ идэвхтэй, мэдээлэлтэйгээр оролцох нь хүний эрхэд суурилсан хандлагатай нийцэж, төрийн удирдлагын сайн зарчим болон нийгмийн хариуцлагыг хангадаг.²
3. Нийгмийн амьдралд оролцох зарчим нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 21 дүгээр зүйлд баталгаажсан бөгөөд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 25 дугаар зүйлд дахин нотлогдсон. Оролцоо нь хүний эрхийн зарчим, эрхийн хувьд бусад олон улсын хүний эрхийн баримт бичигт мөн тусгагдсан байдаг.

Жишээлбэл, Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенцийн 5 (с) заалт, Эмэгтэйчүүдийг ялгаварлан

гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн 7 дугаар зүйл, Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 12 болон 23 (1) дүгээр зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц нь оролцоог ерөнхий үүрэг төдийгүй бүхэлдээ хөндлөн шинж чанартай асуудал гэж үздэг. Тодруулбал, гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй (4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг) нягт зөвлөлдөж, идэвхтэйгээр оролцуулах, мөн хяналтын үйл явцад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангах (33 дугаар зүйлийн 3 дахь хэсэг) үүргийг хүлээсэн байдаг.³

4. Ихэнх тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралд нөлөөлөх асуудлаар шийдвэрийг тэдэнтэй зөвлөлдөхгүйгээр, тэдний өмнөөс гаргасаар ирсэн. Гэвч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлгөөн сүүлийн хэдэн 10 жил өрнөж, тэд хүний эрхээ хүлээн зөвшөөрүүлэхийг шаардаж эхэлснээр зөвлөлдөх шаардлагыг чухалчилж үзэх болсон. **"Бидний оролцоогүйгээр бидний асуудлыг бүү шийд"** гэсэн уриа нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хөдөлгөөний философи, түүхтэй шууд холбоотой бөгөөд утга учиртай оролцооны зарчимд тулгуурладаг.
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийтийн амьдралд оролцоход хандлагын, бие махбодын, хууль эрх зүйн, эдийн засгийн, нийгмийн болон мэдээлэл харилцааны ноцтой саад бэрхшээлтэй тулгарсаар байна. Конвенц хүчин төгөлдөр болохоос өмнө хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үзэл бодлыг үл тоомсорлож, тэдний оронд "хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөө" гэх байгууллагуудын байр суурийг илүүд үздэг байсан.
6. Конвенцийн хэлэлцээ, боловсруулалтын явцад төлөөллийн байгууллагаараа дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоо нь бүрэн бөгөөд үр нөлөөтэй оролцоо, хувь хүний бие даасан байдал, өөрөө шийдвэр гаргах эрх чөлөөний зарчмын тод жишээ болсон. Үүний үр дүнд олон улсын хүний эрхийн эрх зүйд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүх хүний эрх, эрх чөлөөний эзэд хэмээн эргэлзээгүйгээр хүлээн зөвшөөрөх болсон.⁴
7. Өөрийн тайлбар, практикт тулгуурлан Хороо нь энэ Ерөнхий тайлбараараа гишүүн улсуудын 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан үүргийг хэрхэн хэрэгжүүлэхийг тодруулахыг зорьж байна. Сүүлийн арван жилд гишүүн улсууд төлөөллийн байгууллагуудад санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлэх, Конвенцийн 33 (2)-т нийцүүлэн байгуулагдсан бие даасан хяналтын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцуулах зэрэг ахиц дэвшил гаргасныг Хороо тэмдэглэж байна. Зарим улс

³ Ижил эх сурвалж, 14 дүгээр догол мөр.

⁴ Ижил эх сурвалж, 16-17 дугаар догол мөрүүд.

мөн төлөөллийн байгууллагуудтай зөвлөлдөж, тэднийг анхны болон тодотгосон тайлан бэлтгэх үйл явцдаа оролцуулсан байна.

8. Гэвч Хороо 4 (3), 33 (3)-д заасан зорилго, үзэл санаа болон бодит хэрэгжилтийн түвшний хооронд үлэмж зөрүү байгааг тэмдэглэж байна. Энэ нь гол төлөв хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг төлөөллийн байгууллагаараа дамжуулан утга учиртайгаар зөвлөлдөж, оролцуулахгүй байгаатай холбоотой.
9. Гишүүн улсууд шийдвэр гаргах үйл явцад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралын бодит туршлага, эрхийн талаарх мэдлэгийг үнэлж, тэднийг төлөөллийн байгууллагаараа дамжуулан оролцуулахын ач холбогдлыг хүлээн зөвшөөрөх ёстой. Мөн Конвенцийн нийтлэг зарчмуудын хэрэгжилт, хяналтын бүх арга хэмжээндээ, түүнчлэн 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр болон түүний зорилтуудыг хэрэгжүүлэхдээ харгалзан үзэх шаардлагатай.

II. 4 (3) БА 33 (3) ДУГААР ЗҮЙЛСИЙН НОРМАТИВ АГУУЛГА

A. "Төлөөллийн байгууллага"-ын тодорхойлолт

10.  Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өөрийн төлөөллийн байгууллагаар (өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага) дамжин оролцоог тэгш хангах нь Конвенцийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг болон 33 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн салшгүй агуулга юм. Эдгээрийг зөв хэрэгжүүлэхийн тулд гишүүн улсууд болон холбогдох оролцогч талууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагын хүрээ, хамрах байдлыг тодорхойлж, улс орон бүрт оршин буй төрөл хэлбэрийн ялгаатай байгууллагуудыг хүлээн зөвшөөрөх шаардлагатай.
11. Хорооноос үзэж байгаагаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага нь Конвенцоор баталгаажуулсан зарчим, эрхийг бүрэн хүндэтгэн, тэдгээрийг хэрэгжүүлэхэд суурилсан, тууштай үйл ажиллагаа явуулдаг байх ёстой. Ийм байгууллагуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдөө удирдаж, чиглүүлж, удирдлагын түвшинд нь гол төлөв оролцож байх ёстой. Гишүүдийн дийлэнх олонх нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдөө байх шаардлагатай.⁵ Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, ХДХВ/ДОХ-той хүмүүсийн байгууллагууд нь мөн Конвенцийн утгаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагад хамаарна. Ийм байгууллагууд дараах нийтлэг шинжүүдийг агуулдаг.

⁵ CRPD/C/11/2, хавсралт II, 3 дугаар догол мөр.

- (a) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамтаараа илэрхийлэх, хамгаалах, дэмжих, хэрэгжүүлэх зорилгоор байгуулагдсан бөгөөд нийтээрээ ийм байгууллага хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн байх;
 - (b) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдөө ажиллаж, төлөөлж, эсвэл албан ёсоор томилогдож, итгэмжлэгдсэн байх;
 - (c) Ихэнх тохиолдолд улс төрийн аль нэг намтай холбогдоогүй, төрийн байгууллага болон бусад төрийн бус байгууллагаас хараат бус байх;
 - (d) Нэг буюу хэд хэдэн хөгжлийн бэрхшээлийн төрөлд тулгуурласан бүлгийг төлөөлж болохын зэрэгцээ бүх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст гишүүнчлэл нээлттэй байх;
 - (e) Тэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүлгүүдийг төлөөлөхдөө тэдний гарал үүсэл, нөхцөл байдлын олон талт шинжийг (жишээлбэл, жендэр, нас, хүйс, угсаа гарал, шилжин суурьшигч эсхүл дүрвэгч байх зэрэг) бүрэн тусган харуулдаг. Ийм төлөөлөл нь огтлолцох онцлог шинжүүд (жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, эмэгтэй, уугуул иргэд) дээр үндэслэсэн дэд бүлгүүдийг агуулж болох бөгөөд төрөл бүрийн бэрхшээлтэй гишүүдээс бүрдэнэ.
 - (f) Үйл ажиллагааны цар хүрээгээрээ орон нутгийн, үндэсний, бүс нутгийн болон олон улсын түвшинд ажиллаж болох;
 - (g) Тэд бие даасан байгууллага, эвсэл, хөгжлийн бэрхшээлийн олон төрөлд чиглэсэн байгууллага, эсхүл нэгдсэн буюу "шүхэр" байгууллагын хэлбэрээр үйл ажиллагаа явуулж болно. Ийм зохион байгуулалтын хэлбэрүүд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хамтын, зохион байгуулалттай, нэгдмэл дуу хоолойг төлөвшүүлж, төрийн байгууллага, олон улсын байгууллага болон хувийн хэвшлийн бусад талуудтай харилцахдаа тэднийг үр нөлөөтэйгээр төлөөлөх боломжийг бүрдүүлдэг.
12. Хорооны тодорхойлсноор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагын төрөл хэлбэрүүд нь дараах байдлаар ангилагдана.
- (a) **Эвсэл, нэгдсэн холбооны байгууллага** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөөллийн байгууллагуудын эвсэл бөгөөд шийдвэр гаргах түвшин бүрт нэгээс хоёр ийм байгууллага байх нь зохистой. Тэд ардчилсан, нээлттэй байж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олон талт байдлыг бүрэн төлөөлөхийн тулд бүх төлөөллийн байгууллагыг гишүүнээрээ хүлээн авах ёстой. Тэднийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдөө удирдаж, чиглүүлж, хянах ёстой. Тэд зөвхөн гишүүн байгууллагуудынхаа нэрийн өмнөөс, харилцан тохирсон асуудлаар дуугарч чадна. Харин хувь хүнийг шууд төлөөлөх боломжгүй. Энэ үүргийг тодорхой бүлгийг төлөөлдөг бие даасан байгууллагууд илүү сайн гүйцэтгэж чадна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдөө аль

байгууллагаар төлөөлүүлэхээ чөлөөтэй шийдэх эрхтэй бөгөөд шүхэр байгууллага оршин байгаа нь хувь хүн болон бусад байгууллагуудын оролцоог сааруулж болохгүй.

- (b) **Олон төрөлт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага** Хөгжлийн бэрхшээлийн төрөл бүрийн төлөөллийг хамруулсан байгууллага бөгөөд ихэвчлэн орон нутгийн болон үндэсний түвшинд, заримдаа бүс нутгийн болон олон улсын түвшинд ч үйл ажиллагаа явуулдаг.
- (c) **Өөрийн эрхийн төлөө дуугардаг байгууллага** (self-advocacy) Өөрсдийнхөө эрхийн төлөө дуу хоолойгоо өргөдөг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд нь ихэвчлэн сул зохион байгуулалттай, эсхүл орон нутгийн түвшинд бүрдсэн сүлжээ, платформын хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, ялангуяа оюуны бэрхшээлтэй хүмүүсийн эрх, ашиг сонирхлыг хамгаалан, дуу хоолойг нь төлөөлж ажилладаг. Ийм байгууллагыг байгуулах, мөн гишүүддээ үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангахын тулд шаардлагатай, зарим тохиолдолд өргөн хүрээтэй дэмжлэг үзүүлэх нь улс төрийн оролцоо, шийдвэр гаргах үйл явцад оролцох, түүнчлэн хэрэгжилт болон хэрэгжилтэд нь хяналт-шинжилгээ хийх үйл ажиллагаанд тэдний оролцоог баталгаажуулах үндсэн нөхцөл болдог. Энэ нь эрх зүйн чадамжийг нь хязгаарласан, байгууллагад албадан байрлуулсан эсхүл санал өгөх эрхийг нь үгүйсгэсэн хүмүүст онцгой ач холбогдолтой. Гэвч олон улс оронд ийм төрлийн байгууллагууд нь гишүүдийнх нь эрх зүйн чадамжийг үл хүлээн зөвшөөрсөн хууль, эрх зүйн зохицуулалтын улмаас эрх зүйн статустай болохоос татгалзах байдлаар ялгаварлан гадуурхагдаж байна.
- (d) **Гэр бүлийн гишүүдийн байгууллага** – Оюуны хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүс болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрх ашгийг хамгаалахад чухал үүрэгтэй. Тухайн бүлгийн хүмүүс гэр бүлийнхнээрээ дэмжүүлэхийг хүсвэл ийм байгууллагыг зөвлөлдөх, шийдвэр гаргах, хяналтын үйл явцад оролцуулах ёстой. Эцэг эх, асран хамгаалагчдын үүрэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дуу хоолойг хүргэх, өөрсдийн амьдралаа бүрэн хянах боломжийг олгох явдал юм. Тэд дэмжлэгтэй шийдвэр гаргалтыг идэвхтэй ашиглаж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн зөвлөлдөх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хүндэтгэх ёстой.
- (e) **Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидын байгууллага** – Эдгээр нь олон төрлийн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидыг төлөөлдөг⁶ бөгөөд жендэрийн тэгш байдлын бодлого болон тэдэнд онцгой эсвэл давуугаар нөлөөлдөг асуудалд оролцоог нь зайлшгүй

⁶ Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидын тухай 3 дугаар Ерөнхий тайлбар (2016 он), 5 дугаар догол мөр.

хангах шаардлагатай.

- (f) **Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын байгууллага, санаачилга** – Эдгээр нь хүүхэд, залуусын нийтийн амьдралд оролцох, үзэл бодлоо илэрхийлэх, чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхийг хэрэгжүүлэхэд чухал. Насанд хүрэгчид хүүхэд, залуучуудын байгууллага, санаачилгыг бий болгох, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй бөгөөд энэ нь албан ёсоор болон албан бус хэлбэрээр хэрэгжиж болно.

В. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага ба бусад иргэний нийгмийн байгууллагын ялгаа

13. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагыг тэдний өмнөөс үйлчилгээ үзүүлдэг, эсвэл тэдний өмнөөс өмгөөлж, төлөөлдөг байгууллагуудаас ("for" байгууллагаас) ялгаж ойлгох ёстой. Ийм байгууллагуудын үйл ажиллагаа нь зарим тохиолдолд ашиг сонирхлын зөрчил үүсгэдэг бөгөөд энэ үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхээс илүүтэйгээр өөрсдийн байгууллагын зорилго, ашиг сонирхлоо хамгаалдаг. Иймд гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өөрийн төлөөллийн байгууллагуудаар дамжуулан тэдний санал, байр суурийг онцгой ач холбогдолтойд тооцож, байгууллагуудын чадавх, эрх мэдлийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлж, шийдвэр гаргах үйл явцад тэдний санал, дуу хоолойд тэргүүлэх ач холбогдол өгөх ёстой.⁷
14. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагыг ерөнхийд нь иргэний нийгмийн байгууллагаас ялгаж ойлгох шаардлагатай. "Иргэний нийгмийн байгууллага" гэдэгт судалгааны байгууллага/хүрээлэн, үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон бусад хувийн оролцогчид зэрэг олон янзын байгууллагууд хамаардаг. Харин хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага бол иргэний нийгмийн байгууллагын доторх тодорхой нэг төрөл юм. Тэдгээр нь өргөн хүрээний иргэний нийгмийн эвсэл, холбоонд харьяалагдаж, тэр бүр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн төлөө шууд ажилладаггүй байж болох ч хүний эрхийн хэлэлцэх асуудлуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг үндсэн чиглэл болгож дэмжин ажиллах боломжтой. Конвенцийн 33 (3) дугаар зүйлд заасны дагуу бүх иргэний нийгмийн байгууллага, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд Конвенцийн хэрэгжилтийг хянах үүрэгтэй.

Гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудалд тэдний төлөөллийн байгууллагын байр суурийг тэргүүнд тавьж, иргэний нийгмийн байгууллага болон бусад оролцогч талуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагыг ажлынхаа нэг хэсэг болгон

⁷ А/НRC/31/62, 38 дугаар догол мөр; мөн А/71/314, 64 дүгээр догол мөр.

оролцуулах, зөвлөлдөх тогтолцоог бий болгох шаардлагатай. Үүнд зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх төдийгүй ялгаварлан гадуурхахын эсрэг бодлого, энх тайван, байгаль орчны эрх зэрэг өргөн хүрээний асуудлууд хамрагдана.

С. 4 (3) дугаар зүйлийн хамрах хүрээ

15. 4 (3) дугаар зүйлд заасан үүргээ хэрэгжүүлэхийн тулд гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагаар дамжуулан тэднийг хууль тогтоох, зохицуулалтын тогтолцоо болон бүх шатны төрийн байгууллагын үйл явцад нягт зөвлөлдөж, идэвхтэй оролцуулах үүргээ хуулийн болон журам, бодлогын түвшинд тусгах ёстой. Түүнчлэн аливаа хууль, журам, бодлогыг батлахаасаа өмнө, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог зайлшгүй алхам гэж үзэж, тэднийг зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст чиглэсэн асуудлаар бус өргөн цар хүрээтэй бодлого, хууль тогтоомжийн хэлэлцүүлэгт заавал хамруулах ёстой. Ийм зөвлөлдөх үйл явц шийдвэр гаргах бүх шатанд аль болох эрт эхэлж, эцсийн шийдвэрт бодит хувь нэмэр оруулах боломжийг бүрдүүлэх шаардлагатай. Зөвлөлдөх үйл явц нь хөгжлийн бэрхшээлийн төрөл, олон талт байдлыг илэрхийлсэн байгууллагуудыг орон нутгийн, үндэсний, бүс нутгийн болон олон улсын түвшинд хамруулах ёстой.
16. Ямар ч төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тухайлбал сэтгэцийн болон оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг үл ялгаварлан, тэгш үндсэн дээр үр дүнтэй, бүрэн оролцох эрхтэй.⁸ Төлөөллийн байгууллагаар дамжуулан зөвлөлдөх үйл явцад оролцох энэ эрхийг хөгжлийн бэрхшээлтэй бүх хүнд, жишээлбэл, бэлгийн чиг баримжаа, жендэрийн илэрхийллээс үл хамааран адил тэгш хүлээн зөвшөөрөх ёстой. Иймд гишүүн улсууд бүх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, эрх чөлөөг хамгаалах иж бүрэн ялгаварлан гадуурхахын эсрэг тогтолцоог батлан хэрэгжүүлэх, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүйс, жендэр, нийгмийн байдал гэх мэт шалтгаанаар ялгаварлаж, тэдний нийтийн болон улс төрийн амьдралд оролцох эрхийг үгүйсгэсэн хууль тогтоомжоо цуцлах ёстой.
17. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагатай зөвлөлдөхийг хангах гишүүн улсын хууль эрх зүйн үүрэг нь зөвхөн төрийн шийдвэр гаргах орон зайгаар хязгаарлагдахгүй. Үүнд судалгаа, түгээмэл загвар, түншлэл, эрх шилжүүлэлт, иргэдийн хяналт зэрэг бусад салбарууд ч хамрагдана. Түүнчлэн энэ үүрэг нь зөвхөн үндэсний түвшинд бус, бүс нутгийн болон олон улсын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагыг хамрах ёстой.⁹

⁸ А/HRC/19/36, 15–17 дугаар догол мөрүүд.

⁹ А/HRC/31/62, 63 дугаар догол мөр; мөн А/HRC/34/58, 63 дугаар догол мөр.

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хамаарах асуудлууд

18. Конвенцийн 4 (3) дугаар зүйлд дурдсан "хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хамаарах асуудлууд" гэсэн хэллэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхэд шууд болон шууд бусаар нөлөөлөх хууль тогтоомж, захиргааны болон бусад бүх арга хэмжээг хамарна. Энэ ойлголтыг өргөн хүрээнд тайлбарласнаар гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлийг нийгмийн бүх бодлогод тусгаж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусадтай тэгш авч үзэх нөхцөлийг хангах боломжтой. Мөн ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэдлэг, амьдралын туршлагыг хууль тогтоомж, захиргааны болон бусад арга хэмжээг шинээр боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад тусгах боломж бүрдэнэ. Үүнд ерөнхий хууль тогтоомж, улсын төсөв зэрэг өргөн хүрээний асуудлууд болон зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст чиглэсэн хууль тогтоомж багтана.¹⁰
19. 4 (3) дугаар зүйлийн дагуу хийсэн зөвлөлдөх үйл явц нь гишүүн улсыг Конвенц болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхтэй зөрчилдөх аливаа үйл ажиллагаа, практик хэрэгжүүлэхээс сэргийлдэг. Хэрэв тухайн арга хэмжээ шууд болон шууд бусаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нөлөөлөх эсэх талаар маргаан гарвал, тухайн асуудал хэт нэг талыг барьсан, сөрөг үр дагавартай биш гэдгийг нотлох үүрэг гишүүн улсын төрийн байгууллагад ногдоно.
20. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст шууд хамаарах асуудлын жишээнд: институтчлэхгүй байх (deinstitutionalization), нийгмийн даатгал ба хөгжлийн бэрхшээлийн тэтгэвэр, хувийн туслах үйлчилгээ, хүртээмжийн шаардлага, зохистой зохицуулалтын бодлого орно. Шууд бус байдлаар нөлөөлөх асуудлын жишээнд: Үндсэн хууль, сонгох эрх, шударга шүүхийн хүртээмж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бодлогыг удирдах захиргааны байгууллагын томилгоо, боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр, эрхлэлтийн салбарын нийтлэг бодлогууд хамаарна.

2. "Нягт зөвлөлдөх ба идэвхтэй оролцуулах"

21. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өөрсдийн төлөөллийн байгууллагаар дамжуулан "нягт зөвлөлдөх ба идэвхтэй оролцуулах" нь олон улсын хүний эрхийн хуулиар заасан үүрэг бөгөөд энэ нь хувь хүний эрх зүйн чадамж, бие даасан байдал, өөрөө шийдвэр гаргах эрхийг хүлээн зөвшөөрөхөд тулгуурлана. Конвенцыг хэрэгжүүлэх болон бусад шийдвэр гаргах үйл явцад хийх зөвлөлдөх, оролцуулах ажлууд нь хөгжлийн бэрхшээлтэй бүх хүнийг хамрах бөгөөд шаардлагатай тохиолдолд дэмжлэгтэй шийдвэр гаргах тогтолцоог ашиглах ёстой.

¹⁰ A/HRC/31/62, 64 дүгээр догол мөр.

22. Гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудыг системтэйгээр, ил тод, утга учиртайгаар, цаг тухайд нь зөвлөлдөж, оролцуулах шаардлагатай. Энэ нь төрийн байгууллагын цахим хуудсуудыг хүртээмжтэй форматаар (жишээлбэл, дохионы хэлний орчуулагч, энгийн хэллэгтэй тайлбар, уншихад хялбар формат, Брайль, тактиль харилцаа гэх мэт) мэдээлэл өгөх, шаардлагатай үед зохистой зохицуулалт хийх зэрэг бүхий л хэлбэрээр хийгдэнэ. Нээлттэй зөвлөлдөх үйл явц нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст Конвенцийн хэрэгжилт, хяналтын хүрээнд холбогдох бүх төрийн шийдвэр гаргах орон зай, үндэсний сангууд болон байгууллагуудын үйл ажиллагаанд бусадтай адил тэгш оролцох боломж олгоно.
23. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст шууд хамаарах асуудлыг хэлэлцэхдээ төрийн байгууллагууд тэдгээрийн төлөөллийн байгууллагуудын санал, байр суурийг бодитоор харгалзан үзэж, тэргүүнд тавих ёстой. Шийдвэр гаргаж буй төрийн байгууллагууд эдгээр байгууллагуудад гарсан шийдвэрийн үр дүнг ойлгомжтой хэлбэрээр тайлагнаж, санал бодлыг хэрхэн тусгасан болон ямар үндэслэлээр өөр шийдвэр гаргасныг тодорхой тайлбарлан хүргэх үүрэгтэй.

3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг оролцуулах

24. 4 (3) дугаар зүйл нь Конвенцийг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, мөн бусад шийдвэр гаргах үйл явцад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг системтэйгээр оролцуулахын чухлыг онцолж, хүүхдийн байгууллага, эсвэл тэднийг дэмжих бүтцээр дамжуулан оролцоог нь баталгаажуулдаг. Ийм байгууллагууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бие даасан байдал, идэвхтэй оролцоог дэмжих, баталгаажуулахад чухал үүрэгтэй. Гишүүн улсууд ийм байгууллагыг байгуулах, тогтвортой ажиллуулах нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн оролцооны эрхийг дэмжих хүрээнд шаардлагатай нөөц, дэмжлэгийг олгох ёстой.
25. Гишүүн улсууд хүүхдийн эрхийн тухай ойлголтыг дээдэлж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хүсэл зориг, сонголтыг хүндэтгэх хууль, журам, хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх ёстой. Хүүхдийн хөгжлийн үе шат, хувь хүний өөрчлөгдөж буй чадамжийг харгалзан үзэх нь зайлшгүй бөгөөд хувь хүний бие даасан байдлын эрхийг баталгаажуулах нь хөгжлийн бэрхшээлтэй бүх хүнийг эрхийн эзэн болгон хүлээн зөвшөөрөхөд онцгой ач холбогдолтой.¹¹

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд өөрсдийн хэрэгцээ, туршлагыг хамгийн сайн илэрхийлэх боломжтой бөгөөд энэ нь зохистой хууль, бодлого боловсруулахад нэн чухал мэдээлэл болдог.

26. Гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог хангахын

¹¹ Конвенцийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг. Хүүхдийн эрхийн хорооноос гаргасан “Хүүхдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн тухай” 12 дугаар Ерөнхий тайлбар (2009 он)-ын 134 дүгээр догол мөрийг үз.

тулд семинар, уулзалт зохион байгуулж, тэднийг өөрийн байр сууриа илэрхийлэхийг урьж болно. Мөн тодорхой сэдвээр эссэ бичүүлэх уралдаан явуулж, хүүхдийн өөрсдийн амьдралын туршлага, хүлээлтийг тодорхойлсон бүтээлийг цуглуулан, тэдгээрийг бодлогын баримт бичиг, шийдвэр гаргах үйл явцад шууд ашиглах боломжтой.

4. Бүрэн бөгөөд үр нөлөөтэй оролцоо

27. Нийгмийн амьдралд (3 дугаар зүйлийн (с) заасан) "бүрэн бөгөөд үр нөлөөтэй оролцоо" гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцуулаад бүх хүнд хамаарна. Энэ нь хүн бүрийг нийгэмд хамааралтай, нийгмийн нэг хэсэг гэсэн мэдрэмжийг төрүүлэхүйц оролцоог хангахыг хэлдэг. Үүнд нийгэмд идэвхтэй оролцохыг дэмжих, тохирсон дэмжлэг (жишээлбэл, хамт олны харилцан дэмжлэг болон бусад хэлбэрийн туслалцаа) авах, нийгмийн орон зайд өөрийгөө чөлөөтэй илэрхийлэхэд гутаан доромжлолгүй, аюулгүй, хүндэтгэлтэй орчин бүрдүүлэх зэрэг багтана. Бүрэн бөгөөд үр нөлөөтэй оролцоог хангахын тулд гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэрийн өргөн хүрээ, олон талт байдлыг төлөөлсөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог дэмжиж, зөвлөлдөх үүрэгтэй.
28. Оролцох эрх нь иргэний болон улс төрийн эрх бөгөөд нэн даруй хэрэгжих зайлшгүй үүрэг юм. Энэ эрх нь ямар нэг төсвийн хязгаарлалттай холбогдохгүй, Конвенцийн хэрэгжилттэй холбоотой бүх шийдвэр гаргалт, хэрэгжилт болон хяналтын үйл явцад адилхан хамаарна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудын оролцоог эдгээр бүх үе шатанд баталгаажуулснаар, тэд өөрсдийн эрхийг дээшлүүлэх, эсвэл бууруулж болзошгүй арга хэмжээг тодорхойлох, санал болгох боломжтой болж, эцсийн дүндээ илүү чанартай, эрхэд нийцсэн шийдвэр гарахад хувь нэмэр оруулна. Бүрэн бөгөөд үр нөлөөтэй оролцоо нь нэг удаагийн үйл явдал бус харин **тасралтгүй явагдах процесс** гэдгээрээ онцлог юм.¹²
29. Конвенцийг хэрэгжүүлэх, хянах үйл явцад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоо нь тэдний **илэрхийлэх эрх чөлөө, тайван цуглаан хийх эрх, эвлэлдэн нэгдэх эрх** (Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19, 21, 22 дугаар зүйл) хэрэгжсэн нөхцөлд л боломжтой болно.

Конвенцийг хэрэгжүүлэх, хянах үйл явцад оролцож буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний төлөөллийн байгууллагыг **хүний эрхийн хамгаалагчийн**¹³ хувьд хүлээн зөвшөөрч, ялангуяа санал

¹² 12 дугаар Ерөнхий тайлбар, 133 дугаар догол мөр.

¹³ Ерөнхий Ассамблейн 53/144 тоот тогтоол, хавсралтыг үз.

зөрөх үед нь айлган сүрдүүлэлт, дарамт шахалт, өшөө авалт зэрэг аливаа хэлбэрийн халдлагаас хамгаалах ёстой.

30. Оролцох эрх нь шударга шүүхийн ажиллагааны баталгаа, үзэл бодлоо илэрхийлэх эрх (right to be heard) зэрэг хүний эрхийн бусад үүргийг ч багтаадаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудтай нягт зөвлөлдөж, идэвхтэй оролцуулж буй гишүүн улс орнууд энэ эрхийг хангаж байгаа хэрэг бөгөөд ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олон нийтийн болон улс төрийн амьдралд бүрэн, үр нөлөөтэй оролцох эрх (сонгох, сонгогдох эрх – Конвенцийн 29 дүгээр зүйл) бодитоор хэрэгжинэ.
31. Бүрэн бөгөөд үр нөлөөтэй оролцоо гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг орон нутгийн, бүсийн, улсын болон олон улсын түвшний янз бүрийн шийдвэр гаргах байгууллагуудад багтаахыг хэлнэ.

Үүнд үндэсний хүний эрхийн байгууллага, түр хороо, зөвлөл, бүс нутгийн болон орон нутгийн байгууллагууд багтана. Гишүүн улсууд хууль тогтоомж, практикт хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн төлөөллийн аливаа байгууллагад нэр дэвших, сонгогдох боломжтой болохыг баталгаажуулах ёстой. Жишээ нь, орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвлөлд тэднийг нэр дэвшүүлэх, эсвэл үндэсний хүний эрхийн байгууллагын бүтэц дэх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудал хариуцсан албан тушаалд томилохыг баталгаажуулах хэрэгтэй.

32. Гишүүн улсууд олон улсын түвшинд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудын оролцоог идэвхжүүлэх ёстой. Жишээлбэл, Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг хянах өндөр түвшний улс төрийн форум, бүс нутгийн болон олон улсын хүний эрхийн тогтолцоонд оролцох боломжийг хангах шаардлагатай. Ийнхүү төлөөллийн байгууллагаар дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог баталгаажуулснаар төрийн нөөцийг илүү тэгш, үр нөлөөтэй ашиглах, улмаар тэдний болон хамт олны амьдралд илүү сайн үр дүн авчирна.
33. Бүрэн бөгөөд үр нөлөөтэй оролцоо нь нийгмийн өөрчлөлтийн **шилжилтийн хэрэгсэл** болж, хувь хүний идэвх, чадамжийг бэхжүүлдэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудыг бүх түвшний шийдвэр гаргалтад оролцуулах нь тэднийг өөрийн эрхийг хамгаалах, хэлэлцээр хийх чадварт сургахын зэрэгцээ үзэл бодлоо илүү баттай илэрхийлэх, өөрийн хүсэл, зорилгодоо хүрэх, хамтын болон олон талт дуу хоолойгоо бэхжүүлэхэд тусалдаг. Тиймээс гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өөрсдийн төлөөллийн байгууллагаар дамжуулан бүрэн бөгөөд үр нөлөөтэй оролцуулах нөхцөлийг бүрдүүлснээр тэднийг нийгэмд тэгш хамруулах, ялгаварлан гадуурхалтыг арилгах гол арга хэрэгсэл болж чадна.

Ийм оролцоог хангаж буй гишүүн улсууд илүү ил тод, хариуцлагатай болж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бодит хэрэгцээнд нийцсэн хариу арга хэмжээ авдаг.¹⁴

D. 33 дугаар зүйл: Иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо, үндэсний хэрэгжилт ба хяналт

34. Конвенцийн 33 дугаар зүйл нь үндэсний хэрэгжилтийн механизмыг болон бие даасан хяналтын тогтолцоог бий болгож, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудыг түүнд оролцуулахыг баталгаажуулдаг. Иймд 33 дугаар зүйлийг 4 дүгээр зүйлийн (3)-тай хамтатган уншиж ойлгох ёстой.

35. 33 дугаар зүйлийн (1)-д зааснаар, гишүүн улсууд Конвенцийн хэрэгжилтийг хангах, түүнтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулахын тулд нэг буюу хэд хэдэн гол хариуцагч (focal point) болон/эсвэл зохицуулах механизмыг бий болгох үүрэгтэй. Хорооноос гишүүн улсуудын эдгээр гол цэг, зохицуулах механизмуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагын төлөөллийг багтааж, Конвенцийн хэрэгжилттэй холбоотой зөвлөлдөх үйл явцад эдгээр байгууллагуудтай тогтмол харилцах, албан ёсны оролцооны журамтай байхыг зөвлөж байна.

36. 33 дугаар зүйлийн (2)-т нийцүүлэн, Хороо Конвенцийн хэрэгжилтийг хянах бүх үе шатанд бие даасан хяналтын тогтолцоог, үүнд үндэсний хүний эрхийн байгууллагуудыг байгуулах, хадгалах, бэхжүүлэхийн ач холбогдлыг онцлон тэмдэглэсэн.¹⁵

Ийм байгууллагууд нь Конвенцийн хэрэгжилтийн хяналтын үйл явцад гол үүрэг гүйцэтгэж, үндэсний түвшинд нийцлийг хангах, мөн төрийн байгууллага, иргэний нийгмийн оролцоотойгоор хүний эрхийг хамгаалах, дэвшүүлэхэд зохицуулсан үйл ажиллагааг идэвхжүүлэхэд чухал ач холбогдолтой.

37. 33 дугаар зүйлийн (3)-т гишүүн улсууд иргэний нийгмийг Конвенцоор тогтоосон бие даасан хяналтын тогтолцоонд оролцуулах, түүний хэрэгжилтэд оролцох нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэйг онцолжээ. Энэ оролцоонд зайлшгүй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөөллийн байгууллагууд хамрагдах ёстой.

38. Гишүүн улсууд бие даасан хяналтын тогтолцоо нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудыг албан ёсны механизмын хүрээнд идэвхтэй оролцуулах, тэдний дуу хоолойг тайлан, шинжилгээний ажилд тусгах,

¹⁴ А/HRC/31/62, 1–3 дугаар догол мөрүүд.

¹⁵ CRPD/C/GBR/CO/1, 7 ба 37 дугаар догол мөрүүд; CRPD/C/BIH/CO/1, 58 дугаар догол мөр; CRPD/C/ARE/CO/1, 61 дүгээр догол мөр; мөн CRPD/C/SRB/CO/1, 67 дугаар догол мөр.

хүлээн зөвшөөрөх боломжийг хангах ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудын оролцоо нь янз бүрийн хэлбэртэй байж болох ба жишээлбэл, хяналтын тогтолцооны удирдах зөвлөлд эсвэл зөвлөх байгууллагад төлөөлөлтэй байх зэргээр хэрэгжиж болно.

39. 33 дугаар зүйлийн (3)-т заасны дагуу гишүүн улсууд иргэний нийгмийн байгууллагуудын, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, санхүүжүүлэх ёстой. Тэдгээр байгууллагууд нь бие даасан, өөрсдөө удирддаг санхүүжилтийн механизмаар хангагдаж, бие даасан хяналтын тогтолцоонд оролцох, гишүүдийнхээ хүртээмж, зохистой тохируулгын хэрэгцээг хангах боломжтой байх ёстой. Ийм дэмжлэг, санхүүжилт нь гишүүн улсуудын Конвенцийн 4 дүгээр зүйлийн (3)-т хүлээсэн үүргийг нөхөж буй хэрэг бөгөөд үүнийг орлох үндэслэл болохгүй.
40. Конвенц болон хэрэгжилтийн стратеги нь бүх төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөөллийг хамруулан, хүртээмжтэй хэлбэрээр орчуулагдаж, олон нийтэд нээлттэй хүрч байх ёстой. Гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг шийдвэр гаргалтад оролцож, өөрсдийн санал бодлыг илэрхийлэх боломжтой болгохын тулд мэдээлэлд нэвтрэх эрхийг нь хангаж, ойлгомжтой, хүртээмжтэй мэдээллээр хангах шаардлагатай.
41. 33 дугаар зүйлийн (3)-ыг хэрэгжүүлэхийн тулд гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд Засгийн газрын гол цэг болон зохицуулах механизмуудад **шуурхай, хялбар нэвтрэх боломжтой** нөхцөлийг бүрдүүлэх ёстой.

III. ГИШҮҮН УЛСУУДЫН ҮҮРЭГ

42. Хороо нь дүгнэлтдээ гишүүн улсуудыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тэдний төлөөллийн байгууллагуудаар дамжуулан, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд болон хүүхдүүдийг төлөөлж буй байгууллагуудыг багтаан, хууль тогтоомж болон бодлого боловсруулах, Конвенцийг хэрэгжүүлэх, түүнчлэн бусад шийдвэр гаргах үйл явцад цаг тухайд нь нягт зөвлөлдөх, идэвхтэй оролцуулах үүрэгтэйг нь дахин сануулсан.
43. Гишүүн улсууд зөвлөлдөх үйл явцын **ил тод байдлыг хангах, хүртээмжтэй, ойлгомжтой мэдээлэл олгох, мөн эртнээс болон тасралтгүй оролцоог баталгаажуулах** үүрэгтэй. Тэд мэдээллийг нуух, хязгаарлах, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудыг зөвлөлдөх үйл явц болон шийдвэр гаргалтын явцад чөлөөтэй байр сууриа илэрхийлэхээс саатуулах ёсгүй. Энэ нь бүртгэлтэй болон

бүртгэлгүй байгууллагуудад адил хамаарна. Учир нь **нийгэмлэг байгуулах эрх (эрхийн чөлөөт холбоо байгуулах эрх)** нь хуулиар баталгаажсан байх ёстой бөгөөд бүртгэлгүй байгууллагуудын адил оролцоог хамгаалах учиртай.¹⁶

44. Гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагад өргөн цар хүрээтэй зөвлөлдөх үйл явцад оролцохын тулд урьдчилсан нөхцөл болгон албан ёсоор бүртгүүлсэн байх шаардлага тавьж болохгүй. Гэхдээ ийм байгууллагуудыг **чөлөөтэй, хүртээмжтэй, энгийн бүртгэлийн тогтолцоогоор хангаж**, тэдгээрийн бүртгүүлэн оролцох эрхийг хангах ёстой.¹⁷
45. Гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийтийн шийдвэр гаргалт болон зөвлөлдөх үйл явцтай холбоотой бүх байгууламж, журамд нэвтрэх хүртээмжийг хангах үүрэгтэй. Үүнд: барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, боловсролын орчин, мэдээлэл, харилцаа холбоо, нийтийн үйлчилгээнүүд орно. Түүнчлэн мэдээлэл нь тухайн хүний өөрийн хэл дээр, шинэ мэдээллийн технологи, цахим системүүд, төрийн байгууллагын цахим хуудас зэрэг орчин үеийн хэлбэрүүдээр хүртээмжтэй байх шаардлагатай.¹⁸ Хот, хөдөөгийн аль ч нөхцөлд эдгээр боломж тэгш хангуулагдсан байх ёстой. Зөвлөлдөх үйл явцыг хүртээмжтэй болгохын тулд дохионы хэлний орчуулга, Брайль үсэг, уншихад хялбар формат зэрэг дэмжлэгийг үзүүлэх шаардлагатай бөгөөд оролцоог бүрэн хангахын тулд гишүүн улсууд санхүүгийн болон шаардлагатай тохируулгын дэмжлэгийг (шаардсан тохиолдолд) үзүүлэх ёстой.
46. Мэдрэхүйн болон оюуны бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд, тэдний өмгөөллийн байгууллагууд, түүнчлэн сэтгэц-нийгмийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын оролцоог хангахын тулд зохих дэмжлэг үзүүлэх нь зайлшгүй шаардлагатай. Үүнд уулзалтын үеэрх туслах болон дэмжлэг үзүүлэх ажилтан, хүртээмжтэй хэлбэрээр бэлтгэсэн мэдээлэл (жишээлбэл: энгийн хэл, хялбар уншлага, нэмэлт болон орлуулах харилцааны арга хэрэгсэл, дүрс тэмдэг), дохионы хэлний орчуулга, дүлий-хараагүй иргэдэд зориулсан чиглүүлэгч орчуулагч, олон нийтийн хэлэлцүүлгийн үеэр хадмал орчуулга зэрэг орно.¹⁹ Түүнчлэн, Гишүүн улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагын төлөөлөгчдийн зөвлөлдөх үйл явцад оролцоход шаардагдах тээвэр болон бусад зайлшгүй зардлыг нөхөх санхүүгийн нөөцийг төсөвтөө тусгах үүрэгтэй. Энэ нь зөвхөн оролцоог дэмжих төдийгүй, бодитой, тэгш оролцоог баталгаажуулах суурь нөхцөл болдог.

47. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудтай зөвлөлдөх үйл

¹⁶ A/HRC/31/62, 45 дугаар зүйл; болон A/HRC/20/27, 56 дугаар зүйл.

¹⁷ A/HRC/31/62, 40 дүгээр зүйл.

¹⁸ Ерөнхий тайлбар №6 (2018) - Тэгш байдал ба ялгаварлан гадуурхахгүй байх тухай, 23 ба 40 дүгээр зүйлс.

¹⁹ Ижил эх сурвалж, 78–80 дугаар зүйлс.

явц нь **ил тод байдал, харилцан хүндлэл, бодитой яриа хэлэлцээ, хамтын шийдэлд хүрэх чин сэтгэлтэй эрмэлзэл** дээр үндэслэгдэх ёстой. Ийм үйл явц нь бодитой, зохистой хугацааг харгалзан үзэх шаардлагатай, учир нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд ихэвчлэн сайн дурын ажилтнуудад тулгуурладаг. Гишүүн улсууд зөвлөлдөх, оролцооны механизмуудынхаа үйл ажиллагаанд үе шаттай үнэлгээ хийхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудыг идэвхтэй хамруулах ёстой.²⁰

48. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудаар дамжуулан илэрхийлсэн санал бодлыг зохих ёсоор үнэлэх ёстой.²¹ Гишүүн улсууд тэднийг зүгээр л ёс төдий сонсох, эсвэл зөвлөлдөх үйл явцыг "чимэглэл" болгоашиглах ёсгүй.²² Харин зөвлөлдөх үйл явцын үр дүнг шийдвэртээ тусган, оролцогчдод процессын дүнг ойлгомжтойгоор мэдээлэх шаардлагатай.²³
49. Гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудтай нягт, үр дүнтэй зөвлөлдөж, тэднийг идэвхтэй оролцуулсны үндсэн дээр төрийн бүх шат, бүх салбарын хүрээнд ийм байгууллагуудын үзэл бодлыг албан ёсоор авч үздэг ил тод, зохистой механизм, журмуудыг бий болгож хэрэгжүүлэх ёстой.
50. Гишүүн улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудтай нягт зөвлөлдөх, тэднийг идэвхтэй оролцуулах үүрэгтэй. Ийм байгууллагууд нь хөгжлийн бэрхшээлтэй бүх хүнийг төлөөлөх ёстой бөгөөд, үүгээр хязгаарлахгүйгээр: хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, өндөр настан, хүүхэд, өндөр түвшний дэмжлэг шаардлагатай хүмүүс²⁴, газрын тэсрэх зэвсгийн хохирогчид, цагаач, дүрвэгсэд, орогнол хүсэгчид, дотооддоо шилжин суурьшсан иргэд, бичиг баримтгүй болон харьяалалгүй хүмүүс, бодит эсхүл төсөөлөгдөж буй сэтгэц-нийгмийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, оюуны бэрхшээлтэй хүмүүс, мэдрэлийн олон янз байдлыг илэрхийлэгчид (жишээлбэл аутизм болон сэтгэцийн доройтол), альбинизмтай хүмүүс, байнгын эрүүл мэндийн бэрхшээлтэй хүмүүс, архаг өвдөлттэй хүмүүс, уяман өвчинтэй хүмүүс, хараа, сонсголын бэрхшээлтэй иргэд болон ХДХВ/ДОХ-той хүмүүс хамаарна.

Мөн ижил хүйстэн, трансгендер, интерсекс зэрэг тодорхой бэлгийн чиг баримжаа, жендэрийн баримжаатай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, уугуул иргэд, үндэсний, угсаатны, шашны, хэлний цөөнхийн төлөөлөлтэй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хөдөөгийн орчинд амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулах ёстой.

51. Гишүүн улсууд гуравдагч этгээдийн үйлчилгээ үзүүлэгчид зэрэг

²⁰ A/HRC/31/62, 75–77 дугаар зүйлс.

²¹ CRPD/C/COL/CO/1, 11 (а) дугаар зүйл.

²² Хүүхдийн эрхийн хороо, Ерөнхий тайлбар №12, 45 дугаар зүйл.

²³ CRPD/C/ARM/CO/1, 6 (а) дугаар зүйл.

²⁴ Хүүхдийн эрхийн хороо, Ерөнхий тайлбар №12, 132 дугаар догол мөр.

оролцогчид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн Конвенцтой холбоотой шийдвэр гаргалтын үйл явцад нягт зөвлөлдөж, идэвхтэй оролцох эрхэд шууд болон шууд бусаар халдах, ялгаварлан гадуурхах бусад үйлдлийг хориглох ёстой.

52. Гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зөвлөлдөх, оролцох эрхээ эдлэх боломжийг хангах, мөн тэднийг бусдын дарамтаас ангид байлгах зорилгоор хууль, бодлого батлан хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд гэр бүлийнхэн, үйлчилгээ үзүүлэгчид, төрийн албан хаагчдад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийтийн болон улс төрийн амьдралд оролцох эрхийн талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх арга хэмжээнүүд орно. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагын төлөөлөгчид болон бусад оролцогчдын ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх, улмаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бие даасан байдал, хүсэл зориг, сонголтод сөргөөр нөлөөлөхөөс урьдчилан сэргийлэх механизмыг бий болгох ёстой.
53. Конвенцийн 4 дүгээр зүйлийн (3)-ын дагуу гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой хууль, бодлого, стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө зэрэг асуудлаар тэдгээрийн байгууллагуудаар дамжуулан бүрэн, тэгш оролцоог хангах хууль, журам, механизмыг батлан хэрэгжүүлэх үүрэгтэй. Иймд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудыг байнгын хороо, түр ажлын хэсэг зэрэгт албан ёсны гишүүнээр ажиллуулах, төлөөлөл илгээх эрхийг олгох ёстой.
54. Гишүүн улсууд албан ёсны зөвлөлдөх журмыг тогтоож, судалгаа, уулзалт болон бусад арга хэлбэрийн төлөвлөлтийг хийж, зохистой хугацаа тогтоон, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудыг эртнээс хамруулж, холбогдох мэдээллийг урьдчилан, өргөн хүрээнд түгээх хэрэгтэй. Түүнчлэн эдгээр байгууллагуудтай зөвлөлдөх хүртээмжтэй цахим хэрэгсэл бий болгох, эсвэл өөр хүртээмжтэй дижитал хэлбэрийн аргыг санал болгох шаардлагатай. Хэн ч зөвлөлдөх үйл явцаас хоцрохгүй байхын тулд оролцоог хянах, төлөөлөл багатай бүлгүүдийг илрүүлэх, хүртээмж ба зохистой тохируулгын шаардлагыг хангах тусгай албан тушаалтныг томилох ёстой.
55. Гишүүн улсууд бодлого боловсруулахад бэлтгэл судалгаа, дүн шинжилгээ хийхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудтай зөвлөлдөж, тэднийг оролцуулах ёстой. Мөн бодлогын төсөл хэлэлцэх олон нийтийн хэлэлцүүлэг, процесс нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст оролцоход бүрэн хүртээмжтэй байх шаардлагатай.
56. Гишүүн улсууд бие даасан хяналтын тогтолцоогоор дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагын оролцоог хангахдаа тодорхой журам, зохистой хугацаа тогтоон, урьдчилан

мэдээллийг түгээх ёстой. Хяналт, үнэлгээний системүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд бүх бодлого, хөтөлбөрт ямар түвшинд оролцож буйг шинжилж, тэдний санал бодлыг тэргүүнд тавьж байгаа эсэхийг шалгах ёстой. Үйлчилгээ хүргэх үндсэн үүргээ хэрэгжүүлэхийн тулд гишүүн улсууд үйлчилгээний хэрэглэгчид болох хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудтай түншлэл тогтоож, тэднээс санал авах хэрэгтэй.²⁵

57. Гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй бүх бүлгийг хамарсан, тэдний олон янз байдал, тэгш байдлыг хүндэтгэсэн, нэгдмэл төлөөллийн эвсэл байгуулахыг дэмжиж, үндэсний түвшинд Конвенцийн хяналт, хэрэгжилтэд оролцуулах нь зүйтэй. Иргэний нийгмийн байгууллагууд нь ерөнхийдөө хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагыг төлөөлж, орлох боломжгүй.²⁶
58. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өөрсдийнх нь нөлөөлөл хийхийг дэмжиж, тэднийг эрх мэдэлжүүлэх нь нийтийн хэрэгт оролцох чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Үүний тулд техникийн, захиргааны болон харилцааны ур чадварыг хөгжүүлэх, өөрсдийн эрх, хууль тогтоомж, бодлого боловсруулах үйл явцтай холбоотой мэдээлэл, хэрэгсэлд хүртээмжтэй нэвтрэх боломжийг бүрдүүлэх шаардлагатай.
59. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүртээмжтэй боловсролд тулгарч буй саад бэрхшээл нь тэдний нийтийн шийдвэр гаргалтад оролцох боломжийг хязгаарлаж, улмаар байгууллагуудын институцийн чадавхид сөргөөр нөлөөлдөг. Мөн нийтийн тээврийн хүртээмжгүй байдал, зохистой тохируулгын дутагдал, хангалтгүй орлого, ажилгүйдэл зэрэг нь иргэний нийгмийн аливаа үйл ажиллагаанд оролцох чадамжийг хязгаарладаг.
60. Гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудыг бодлого боловсруулах бүх үе шатанд оролцуулахын тулд хүний эрхэд суурилсан хөгжлийн бэрхшээлийн загварын сургалт, чадавх бэхжүүлэх хөтөлбөрийг бие даасан санхүүжилтээр хангах ёстой. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний байгууллагуудыг нийгэмд бүрэн, үр дүнтэй оролцуулахын тулд шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх, хүний эрх, хууль дээдлэх зарчим, ил тод байдал, хариуцлага, олон ургальчилал, оролцоог хүндэтгэх зэрэг ардчилсан засаглалын зарчмуудыг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх шаардлагатай. Үүнээс гадна санхүүжилтэд хэрхэн нэвтрэх, эх үүсвэрээ төрөлжүүлэх талаар зөвлөмж өгөх хэрэгтэй.²⁷
61. Гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд чөлөөтэй, саадгүйгээр бүртгүүлэх, үндэсний болон олон улсын донор, хувийн этгээд, компани, төрийн болон төрийн бус сан,

²⁵ А/71/314, 65–66 дугаар догол мөрүүд.

²⁶ CRPD/C/ESP/CO/1, 6 дугаар догол мөр; болон CRPD/C/NZL/CO/1, 4 дүгээр догол мөр

²⁷ А/HRC/31/62, 47–50 дугаар догол мөрүүд.

иргэний нийгмийн байгууллагууд, мөн төрийн, бүс нутгийн, олон улсын байгууллагуудаас санхүүжилт, дэмжлэг хайх, авах эрхтэй байхыг баталгаажуулах ёстой.²⁸

Хороо гишүүн улсуудыг зөвлөлдөх үйл ажиллагаанд зориулан хөрөнгө хуваарилахдаа дараах шалгуурыг хэрэглэхийг зөвлөж байна:

- (a) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудад хөрөнгийг шууд олгох, гуравдагч этгээдээр дамжуулахгүй байх;
- (b) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн төлөөх нөлөөллийн үйл ажиллагаанд тэргүүн ач холбогдол өгч ажилладаг байгууллагуудад нөөцийг түлхүү чиглүүлэх;
- (c) Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн байгууллагуудад тусгай санхүүжилт хуваарилж, хууль, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх болон хяналт-шинжилгээний үйл явцад тэдний бүрэн, үр дүнтэй оролцоог хангах;²⁹
- (d) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн янз бүрийн байгууллагуудад тэгш хүртээмжтэйгээр хөрөнгийг тарааж, зөвхөн төсөлд суурилсан санхүүжилтээр хязгаарлахгүйгээр тогтвортой институцийн үндсэн санхүүжилт олгох;
- (e) Санхүүжилт авсан ч гэсэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд өөрсдийн нөлөөллийн хөтөлбөр, бодлогоо бие даан тодорхойлох эрх чөлөөг баталгаажуулах;
- (f) Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны санхүүжилтийг тэдний хэрэгжүүлж буй төслүүдийн санхүүжилтээс ялгаж үзэх;
- (g) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүх төрлийн байгууллагад, түүний дотор өөрийн эрхээ хамгаалагчдын байгууллага болон гишүүдийнх нь хууль ёсны чадавхыг үгүйсгэсэн хууль тогтоомжийн улмаас хууль ёсны статустай болж чадаагүй байгууллагуудад ч хүртээмжтэйгээр санхүүжилт олгох;
- (h) Санхүүжилтийн өргөдлийн үйл явцыг хүртээмжтэй хэлбэрээр зохион байгуулах.

62. Гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд үндэсний санхүүжилтэд нэвтрэх боломжийг хангаж, зөвхөн гадаад эх үүсвэрт найдах нөхцөл байдал үүсэхээс зайлсхийх ёстой. Ийм нөхцөл байдал нь тогтвортой байгууллагын бүтэц бий болгох чадавхыг нь хязгаарладаг.³⁰ Төрийн болон хувийн санхүүгийн дэмжлэг, гишүүдийн татварын орлоготой байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг улс төр, захиргааны шийдвэр гаргалтын бүх хэлбэрт оролцуулах, тэдэнд дэмжлэг үзүүлэх, хувь болон бүлэгт чиглэсэн нийгмийн үйл

²⁸ A/HRC/20/27, 67–68 дугаар догол мөрүүд

²⁹ 29 CRPD/C/1/Rev.1, хавсралт.

³⁰ A/59/401, 82 дугаар догол мөрийн (l) ба (t); болон A/HRC/31/62, 51–54 дүгээр догол мөрүүд.

ажиллагаа зохион байгуулах боломжоо баталгаажуулдаг.

63. Гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудад хангалттай, зохистой санхүүжилтийг хууль ёсны, хариуцлагатай албан ёсны механизмаар дамжуулан (жишээ нь, үндэсний болон олон улсын түвшний итгэмжлэлийн сангууд) олгох ёстой.
64. Гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй бүх төрлийн хүмүүсийн байгууллагыг байгуулах, чадавхжуулахад зориулж төрийн нөөцийг нэмэгдүүлэх, тэдэнд үндэсний санхүүжилтэд нэвтрэх боломжийг хангах ёстой. Үүнд татварын чөлөөлөлт, өв залгамжлалын татвараас чөлөөлөгдөх эрх, улсын лото зэрэг эх үүсвэрт нэвтрэх эрхийг баталгаажуулах орно.³¹

Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудыг олон улсын хамтын ажиллагаа болон хөгжлийн тусламжийн хүрээнд, бүс нутгийн түвшинд ч, хүний эрхийн бусад төрийн бус байгууллагуудын адил үндэслэлээр гадаадын санхүүжилтэд нэвтрэх боломжийг дэмжиж, хөнгөвчлөх ёстой.

65. Гишүүн улсууд Конвенцийн 4 дүгээр зүйлийн (3) болон 33 дугаар зүйлийн (3)-ын үүргийг биелүүлээгүй тохиолдолд үр нөлөөтэй, зохистой хариуцлага тооцох механизмыг хөгжүүлж, хэрэгжүүлэх ёстой. Ийм нийцлийг бие даасан байгууллагууд (жишээ нь, хүний эрхийн омбудсменийн газар, парламентын хороо) хянах бөгөөд эдгээр байгууллагууд нь шалгалт явуулах, хариуцлага тооцох эрх мэдэлтэй байх ёстой. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд эдгээр заалтуудыг хэрэгжүүлээгүй этгээдүүдийн эсрэг шүүхийн үйл ажиллагаа эхлүүлэх эрхтэй байх шаардлагатай.³² Ийм механизмууд нь зөвхөн зөвлөлдөх, оролцоог хангах зохицуулалт төдийгүй, үндэсний түвшний ялгаварлан гадуурхахгүй байх хууль тогтоомжийн хүрээнд бүрэн суулгагдсан байх ёстой.³³
66. Гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцох эрхийг хангахын тулд үр нөлөөтэй эрх зүйн хамгаалалтын механизмыг, түүнчлэн **нийтийн шинжтэй хамгаалалт** (collective remedies) буюу **бүлгийн нэхэмжлэл** (class actions)-ийг хүлээн зөвшөөрөх ёстой. Энэ нь эрхээ зөрчүүлсэн нөхцөл байдалд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс шударга шүүхэд нэвтрэх боломжийг бодитоор баталгаажуулахад чухал хувь нэмэр оруулна.³⁴

Үр нөлөөтэй эрх зүйн хамгаалалт нь дараах арга хэмжээг багтааж болно:

(a) тухайн журам, үйл явцыг түр түдгэлзүүлэх;

³¹ А/71/314, paras. 68–69.

³² А/71/314, 68–69 дүгээр догол мөрүүд.

³³ Ерөнхий тайлбар № 6, 72 дугаар догол мөр.

³⁴ Ижил эх сурвалж, 73 дугаар догол мөр.

- (b) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудын зөвлөлдөөн, оролцоог хангах зорилгоор үйл явцыг өмнөх шатанд буцаах;
- (c) зохих зөвлөлдөөн, оролцоо бүрдтэл шийдвэрийн хэрэгжилтийг хойшлуулах;
- (d) 4 дүгээр зүйлийн (3) болон 33 дугаар зүйлийн (3)-ын шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд тухайн шийдвэрийг бүхэлд нь буюу хэсэгчлэн хүчингүй болгох.

IV. КОНВЕНЦИЙН БУСАД ЗААЛТТАЙ УЯЛДАА

67. Конвенцийн 3 дугаар зүйл нь тайлбарлах болон хэрэгжүүлэхэд чиг баримжаа болдог суурь зарчмуудыг тодорхойлдог. Үүнд "нийгэмд бүрэн, үр нөлөөтэй оролцоо, хамрагдалт" хэмээх зарчим багтах бөгөөд энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өөрсдийн төлөөллийн байгууллагаараа дамжуулан оролцох эрх нь Конвенцийн бүхэл бүтэн агуулгад нэвт шингэж, бүх заалтад хамаарна гэсэн утгыг илэрхийлдэг.³⁵
68. Гишүүн улсуудын нийтлэг үүргийн нэг хэсэг болох 4 дүгээр зүйлийн (3) нь Конвенцийн бүхэлд хэрэгжих бөгөөд бүх үүргийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.
69. Конвенцийн 4 дүгээр зүйлийн 1, 2 болон 5 дугаар хэсгүүд нь тус зүйлийн 3 дугаар хэсгийг хэрэгжүүлэхэд онцгой ач холбогдолтой. Учир нь эдгээр хэсгүүд нь Гишүүн улсуудын үндсэн үүргийг багтаадаг бөгөөд улсын бүх хэсэгт ямар нэгэн хязгаарлалт, үл хамааралгүйгээр бүрэн хэрэгжинэ. Гишүүн улсууд шаардлагатай бүтэц, зохицуулалтын тогтолцоог бүрдүүлж, Конвенцийн дагуу үүргээ биелүүлэх арга хэмжээг авах үүрэгтэй.
70. **Эерэг тусгай арга хэмжээ** (affirmative action measures): Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх тэгш байдал ба ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг хэрэгжүүлэх бодлогыг Конвенцийн 5 дугаар зүйлд заасны дагуу, мөн 4 дүгээр зүйлийн 3 болон 33 дугаар зүйлийн 3-т нийцүүлэн баталж, хэрэгжилтийг хянах ёстой.³⁶

Нийгмийн олон талт байдлыг төлөөлдөг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын нягт хамтын ажиллагаа, идэвхтэй оролцоог дэмжсэн эрх тэгш байдлыг бодитоор хангах, болон бодлогын баримт

³⁵ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн дээд комиссар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцийг хэрэгжүүлэх явцыг хянах: Хүний эрхийн хяналт хэрэгжүүлэгчдэд зориулсан гарын авлага, Мэргэжлийн сургалтын цуврал №17 (Нью-Йорк ба Женев, 2010).

³⁶ Ерөнхий тайлбар № 6-г үзнэ үү.

бичгүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах үйл явцын амжилтын үндсэн нөхцөл болдог.

71. Зөвлөлдөх арга хэмжээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хасахгүй, хөгжлийн бэрхшээлийн шинжээр ялгаварлан гадуурхахгүй байх ёстой. Журам болон түүнд холбогдох материал нь хүртээмжтэй, оролцоог хангахуйц байх, цагийн хуваарь болон техникийн туслалцааг урьдчилан төлөвлөж өгөх шаардлагатай. Бүх зөвлөлдөх үйл явцад **шаардлагатай тохируулга (reasonable accommodation)** заавал хангагдах ёстой бөгөөд үүнтэй холбоотой хууль, бодлогыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудтай нягт зөвлөлдөж, тэднийг идэвхтэй оролцуулан боловсруулах шаардлагатай.
72. Конвенцийн 6 дугаар зүйл нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидын бүрэн хөгжил, дэвшил болон чадавхжуулалтыг хангах арга хэмжээг шаарддаг.

Гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийн байгууллагыг байгуулахыг дэмжиж, тэдний нийгмийн амьдралд эрэгтэйчүүдтэй тэгш оролцох боломжийг бий болгох хэрэгсэл болгон ажиллуулах ёстой. Гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд өөрсдийгөө төлөөлөх, зохион байгуулах эрхийг хүлээн зөвшөөрч, 4 дүгээр зүйлийн (3) болон 33 дугаар зүйлийн (3)-ын хүрээнд явагдах зөвлөлдөх үйл ажиллагаанд тэдний үр нөлөөтэй оролцоог хөнгөвчлөх ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидыг хэрэгжилт болон хяналтын бүх байгууллага, механизм, журмуудад эрэгтэйчүүдтэй тэгш оролцуулж, бүх зөвлөлдөх байгууллага, механизмыг хөгжлийн бэрхшээлд нийцсэн, хамруулах ба хүйсийн тэгш байдлыг хангах зарчимд тулгуурлах ёстой.

73. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэйчүүдтэй тэгш үндсэн дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудын удирдлагад оролцуулах ёстой бөгөөд тэдэнд **нэгдсэн холбооны байгууллагуудын хүрээнд** төлөөллийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн хороо байгуулах, чадавхжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх гэх мэт аргаар орон зай, эрх мэдлийг олгох ёстой. Гишүүн улсууд хараа хяналт дор байгаа болон байгууллагад хоригдсон эмэгтэйчүүдийг ч багтаан, тэдний амьдралд нөлөөлөх бүх арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээний шатанд оролцуулахыг заавал хангах үүрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд нь зөвхөн өөрсдөд нь онцгой болон харьцангуй ихээр нөлөөлөх асуудлууд төдийгүй эмэгтэйчүүдийн эрх, хүйсийн тэгш байдлын бодлоготой холбоотой бүх шийдвэр гаргах үйл явцад оролцох ёстой. Үүнд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрх, эмэгтэйчүүдийн эсрэг бүх хэлбэрийн хүчирхийлэл зэрэг бодлогын асуудлууд багтана.

74. 4 дүгээр зүйлийн (3) болон 33 дугаар зүйлийн (3)-ыг хэрэгжүүлэх нь 7 дугаар зүйлд заасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрхийг хангахад үндсэн ач холбогдолтой. Гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг төлөөллийн байгууллагаараа дамжуулан сургуулийн орчноос эхлээд олон улсын түвшин хүртэлх бүх шатанд хамаарах хууль тогтоомж, бодлого, үйлчилгээ, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээнд идэвхтэй оролцуулах арга хэмжээг авах ёстой. Хүүхдийн оролцооны зорилго нь тэднийг эрхийн эзэмшигч гэдгийг хүлээн зөвшөөрч, чадавхжуулан, хамт олондоо болон нийгэмдээ идэвхтэй үүрэг гүйцэтгэх боломжоор хангах явдал юм.³⁷
75. Гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн шийдвэр гаргах үйл явцыг дэмжихдээ шаардлагатай харилцааны бүх хэлбэрийг ашиглах, хүүхдэд ээлтэй мэдээлэл өгөх, өөрийгөө хамгаалан дуу хоолойгоо³⁸ илэрхийлэх чадварыг хөгжүүлэхэд туслах, мэргэжлийн ажилтнуудад зохих сургалт олгох гэх мэт арга хэмжээ авах ёстой. Мөн нас, хөгжлийн онцлогт тохирсон тусламж, журмыг хангах ёстой.³⁹ Тэдний байгууллагуудын оролцоог онцгой ач холбогдолтой гэж үзэж, хүүхдийн нас, боловсрол, төлөвшлийн түвшинд нь тохируулан үзэл бодлыг нь харгалзан үзэх шаардлагатай.
76. 4 дүгээр зүйлийн (3) нь 8 дугаар зүйлтэй (сэргээн таниулах) нягт холбоотой. Хорооны зүгээс гишүүн улсуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудын оролцоотойгоор системтэйгээр олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр, ялангуяа олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлгээр дамжуулан мэдээллийн кампанит ажлыг зохион байгуулахыг зөвлөж байна.⁴⁰ Эдгээр кампанит ажил нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрх эзэмшигчийн хувьд бүх ялгаатай байдлаар нь харуулах зорилготой байх ёстой.
77. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд Конвенцийн хэрэгжилттэй холбоотой зөвлөлдөх болон хяналт-шинжилгээний үйл явцад бүрэн дүүрэн, зохистой оролцохын тулд үйл явц, механизм, мэдээлэл, харилцаа холбоо, байгууламж, барилга байгууламжид (зүй зохистой тохируулгыг ч багтаан) хамгийн дээд түвшний хүртээмж (9 дүгээр зүйл)-ийг хангах нь зайлшгүй чухал.

³⁷НҮБ-ын Хүүхдийн Сан (UNICEF), Өсвөр насныхны оролцооны үр дүнг хянах үзэл баримтлалын хүрээ (2018 оны 3 дугаар сар). Эндээс авах боломжтой: www.unicef.org/adolescence/files/Conceptual_Framework_for_Measuring_Outcomes_of_Adolescent_Participation_March_2018.pdf.

³⁸Хүүхдийн эрхийн хороо, Ерөнхий тайлбар №12, 21 дүгээр догол мөр.

³⁹Ижил эх сурвалж, 34 дүгээр догол мөр.

⁴⁰CRPD/C/MDA/CO/1, 19 дүгээр догол мөр; CRPD/C/AZE/CO/1, 21 дүгээр догол мөр; болон CRPD/C/TUN/CO/1, 21 дүгээр догол мөр.

Гишүүн улсууд олон улсын хүртээмжийн стандартыг болон түгээмэл загвар ашиглах үйл явцыг боловсруулж, баталж, хэрэгжүүлэх ёстой. Жишээлбэл: мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбар⁴¹

ийм арга хэмжээг хэрэгжүүлэх нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудтай нягт зөвлөлдөх, тэднийг идэвхтэй оролцуулах нөхцлийг бүрдүүлдэг.⁴²

78. Эрсдэлтэй нөхцөл байдал, хүмүүнлэгийн онцгой байдлын үед (11 дүгээр зүйл) гишүүн улсууд болон хүмүүнлэгийн байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудыг бүх түвшинд идэвхтэй оролцуулан, утга учиртай зөвлөлдөх ёстой. Дотооддоо шилжин суурьшсан болон дүрвэгсдийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудыг байгуулах, эрхийг нь хамгаалах чадавхтай болгохыг дэмжих хэрэгтэй.
79. Хууль өмнө тэгш хүлээн зөвшөөрөгдөх эрх (12 дугаар зүйл) нь бүх хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүрэн эрх зүйн чадамжаа эдлэх, өөрт нь хамаарах шийдвэрийг сонгох, хянах тэгш эрхтэй болохыг баталгаажуулдаг. Хууль өмнө тэгш хүлээн зөвшөөрөгдөх нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг Конвенцийг хэрэгжүүлэх хууль, бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд шууд, үр нөлөөтэй зөвлөлдөх, оролцоог хангах үндсэн нөхцөл юм. Хорооноос 12 дугаар зүйлийн хэрэгжилт хангагдаагүй байдлыг ямар ч тохиолдолд 4 дүгээр зүйлийн 3, 33 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн хамруулах, хүртээмжтэй хэрэгжилтийг саатуулах үндэслэл болгох ёсгүй гэж зөвлөмжилж байна. Эрх зүйн чадамжийг үгүйсгэсэн дээр суурилсан оролцооны саадыг арилгахын тулд хууль, бодлогыг өөрчлөх шаардлагатай.
80. Хороо "Хуулийн өмнө тэгш хүлээн зөвшөөрөгдөх тухай" 2014 оны 1 дүгээр Ерөнхий тайлбартаа (General Comment No.1) эрх зүйн чадамж нь нийгэмд бүрэн, үр нөлөөтэй оролцох, шийдвэр гаргах үйл явцад оролцох түлхүүр гэж тодорхойлсон бөгөөд энэ нь оюуны бэрхшээлтэй, аутизмтай хүмүүс, бодит эсхүл таамагласан сэтгэц-нийгмийн хүндрэлийн улмаас ялгаварлагдсан хүмүүс, хүүхдүүд зэрэг бүх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст баталгаатай байх ёстой. Улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бие даасан байдал, хүсэл зориг, сонголтыг хүндэтгэж, тэднийг бодлого боловсруулах, зөвлөлдөх үйл явцад оролцуулахад дэмжлэгтэй шийдвэр гаргах зохицуулалтыг бий болгох үүрэгтэй.
81. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шударга шүүхэд хандах эрх (13 дугаар зүйл) нь тэд бусадтай адил тэгш нөхцөлөөр шүүхийн тогтолцоонд бүрэн дүүрэн оролцох эрхийг баталгаажуулдаг.

⁴¹Ерөнхий тайлбар №2 (2014) Хүртээмжийн тухай, 5–7 болон 30 дугаар догол мөрүүд.

⁴²Ижил эх сурвалж, 16, 25 болон 48 дугаар догол мөрүүд.

Энэ оролцоо нь олон хэлбэрээр илэрхийлэгдэх бөгөөд нэхэмжлэгч, хохирогч, яллагдагч, шүүгдэгч, шүүгч, тангарагтны шүүгч, өмгөөлөгч зэрэг үүргийг хүлээх зэргээр ардчилсан тогтолцооны салшгүй

бүрэлдэхүүн болж, сайн засаглалын үйл ажиллагаанд чухал хувь нэмэр оруулдаг.⁴³ Шүүхийн тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангахтай холбоотой хууль, журам, бодлого, хөтөлбөрийг батлах, өөрчлөх бүх үйл явцад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийн байгууллагуудаар дамжуулан нягт зөвлөлдөх нь зайлшгүй урьдач нөхцөл юм.

82. Мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолын бүх хэлбэрээс урьдчилан сэргийлэх (16 дугаар зүйл)-ийн хүрээнд, Гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бүх төрлийн байгууламж, үйлчилгээ, хөтөлбөрийг бие даасан байгууллагаар тогтмол, үр нөлөөтэйгээр хянуулах үүрэгтэй. Хорооноос тэмдэглэснээр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд "үйлчлэх" зорилготой гэж тодорхойлогддог байгууллагуудад, тухайлбал сэтгэцийн эмнэлэг болон асрамжийн байгууллагад хүний эрхийн ноцтой зөрчил өнөөг хүртэл гарсаар байна. 33 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн дагуу, 16 дугаар зүйлийн 3 дахь хэсгээр томилогдсон бие даасан хяналтын байгууллага нь 33 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан бие даасан хяналтын тогтолцоотой давхцах эсэхээс үл хамааран иргэний нийгмийн байгууллагууд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудыг эдгээр байгууламж, үйлчилгээний хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл явцад идэвхтэйгээр оролцуулах ёстой.
83. Хороо "Бие даан амьдрах болон нийгэмд хамрагдах эрхийн тухай" 2017 оны 5 дугаар Ерөнхий тайлбараа сануулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудаар дамжуулан тэдэнтэй зөвлөлдөх, идэвхтэй оролцуулах нь бүх төлөвлөгөө, стратеги батлах, тэдгээрийн хэрэгжилт, хяналт-шинжилгээнд зайлшгүй чухал юм. Шийдвэр гаргах бүхий л түвшинд хөгжлийн бэрхшээлтэй бүх хүнийг оролцуулах ёстой. Тухайлбал, одоогоор байгууллагад амьдарч буй хүмүүсийг ч гэсэн байгууллагаас гаргах стратеги (deinstitutionalization), дэмжлэгийн үйлчилгээ боловсруулах, хэрэгжүүлэх, хянах үйл явцад онцгойлон оролцуулах шаардлагатай.⁴⁴
84. Мэдээлэлд нэвтрэх эрх (21 дүгээр зүйл) нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудыг хяналт-шинжилгээний үйл явцад бүрэн оролцуулах, чөлөөтэй санал бодлоо илэрхийлэх, оролцоог хангахад зайлшгүй шаардлагатай. Ийм байгууллагууд бүх төрлийн хөгжлийн бэрхшээлд тохирсон, цахим форматаар ч, хүртээмжтэй хэлбэрээр мэдээллийг цаг тухайд нь, нэмэлт зардалгүйгээр авах ёстой.

⁴³Beasley v. Australia (CRPD/C/15/D/11/2013), 8.9-р заалт; болон Lockrey v. Australia (CRPD/C/15/D/13/2013), 8.9-р заалт.

⁴⁴Нийтлэг тайлбар №5 (2017) – Бие даан амьдрах ба нийгэмд хамрагдах эрхийн тухай, 71-р заалт

Үүнд дохионы хэл, уншихад хялбар формат, энгийн хэл, Брайль, нэмэлт болон хувилбарт харилцааны хэрэгсэл, бусад хүртээмжтэй арга хэлбэр, горимын хэрэглээг багтаана. Аль ч зөвлөлдөх үйл явцаас

өмнө төсөв, статистик болон бусад холбогдох мэдээллийг цаг тухайд нь, хангалттай хэмжээнд хүргэх ёстой.

85. Тэгш хамран сургах эрхийг (24 дүгээр зүйл) хангахын тулд, "Тэгш хамран сургах эрхийн тухай" Хорооны Ерөнхий тайлбар №4 (2016)-д нийцүүлэн, Гишүүн улсууд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдүүдийг ч багтаан, төлөөллийн байгууллагуудаар нь дамжуулан зөвлөлдөж, тэднийг бодлого, хууль тогтоомжийн бүх шатны төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл явцад идэвхтэй оролцуулах ёстой.⁴⁵ Боловсролд тэгш хамруулах нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог баталгаажуулах үндсэн нөхцөл бөгөөд энэ нь Конвенцийн 4 дүгээр зүйлийн 3 болон 33 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт тусгагдсан зарчмуудтай нийцдэг. Боловсрол нь хувь хүний нийгэмд бүрэн дүүрэн оролцох боломжийг нэмэгдүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэх гол хүчин зүйл бөгөөд ингэснээр Конвенцийн хэрэгжилт, хяналтыг хангахад шаардлагатай нөхцөлийг бүрдүүлдэг. Иймд Гишүүн улсууд нь төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй зөвлөлдөж, тэдний санал бодлыг боловсролын тогтолцоонд зохих ёсоор тусгахыг баталгаажуулах үүрэгтэй.
86. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэх эрх (27 дугаар зүйл)-тэй холбоотой бүх бодлогыг боловсруулахдаа төлөөллийн байгууллагуудтай нь зөвлөлдөж, идэвхтэй оролцуулах ёстой. Ийм бодлогууд нь ажил эрхлэлтийн хүртээмжийг баталгаажуулах; нээлттэй, хамруулсан, ялгаваргүй, хүртээмжтэй, өрсөлдөхүйц хөдөлмөрийн зах зээл, орчныг дэмжих; тэгш боломж, жендэрийн тэгш байдлыг хангах; бүх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зохистой тохируулга, дэмжлэг олгох зорилготой байх ёстой.
87. Хангалттай амьжиргааны түвшин болон нийгмийн хамгааллын эрх (28 дугаар зүйл) нь шууд 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгтэй уялдана. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудын бодлогод оролцох нь ядууралд буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний гэр бүлийн ялгаварлалт, тэгш бус байдал, ядуурлын онцгой нөхцөлийг шийдвэрлэхэд зайлшгүй чухал. Улсууд ажилгүй, тогтмол орлогогүй, эсвэл тэтгэмж, хөнгөлөлтөө алдах эрсдэлээс болж ажил эрхэлж чадахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хөдөө, алслагдсан газар оршин суугчид, уугуул иргэд, эмэгтэйчүүд, өндөр настнуудын байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, идэвхтэй оролцуулах ёстой.

⁴⁵ Нийтлэг тайлбар №5 (2017) – Бие даан амьдрах ба нийгэмд хамрагдах эрхийн тухай, 71-р заалт

28 дугаар зүйлийг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээ, стратеги, хөтөлбөр, бодлого, хууль тогтоомж боловсруулах, хэрэгжүүлэх, хянах бүх шатанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөөллийн

- байгууллагуудтай зөвлөлдөж, оролцоог хангах замаар хөгжлийн бэрхшээлийг бүх нийтийн бодлогод уялдуулах ёстой.
88. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төр, олон нийтийн амьдралд оролцох эрх (29 дүгээр зүйл) нь тэднийг бүрэн, үр нөлөөтэй хамруулах, нийгэмд тэгш оролцоог хангахад нэн чухал ач холбогдолтой. Сонгох болон сонгогдох эрх нь оролцооны үндсэн бүрэлдэхүүн бөгөөд ардчилсан тогтолцооны улс төрийн хөтөлбөрийг тодорхойлох, Конвенцийн хэрэгжилт, хяналтыг хангах, эрх, ашиг сонирхлоо хамгаалахад шийдвэрлэх үүрэгтэй байдаг.
89. Улс орнууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудтай нягт зөвлөлдөн, дэмжлэг шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бие даан саналаа өгөх боломжийг хангах журам гаргах ёстой. Үүнд үндэсний болон орон нутгийн сонгууль, улсын хэмжээнд явагдах бүх нийтийн санал асуулгын үед (сонгуулийн өдөр болон урьдчилсан санал хураалтад) санал өгөх байр, бүхээгт туслах хэрэгслийг байрлуулах зэрэг арга хэмжээ шаардлагатай байж болно.
90. Хөгжлийн бэрхшээлийн өргөн хүрээтэй төрөл, онцлогийг төлөөлж буй хүмүүсийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудаар дамжуулан зөвлөлдөж, өгөгдөл ба мэдээлэл цуглуулах үйл явц, хэрэгжилтэд оролцуулах ёстой (31 дүгээр зүйл).
91. Улс орнууд бүх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний Конвенцийн хүрээнд эдлэх эрхийн хэрэгжилтийн талаарх чанартай, хангалттай, цаг тухайд нь, найдвартай өгөгдлийг цуглуулах нэгдсэн тогтолцоог бий болгох үүрэгтэй. Энэхүү өгөгдөл нь хүйс, нас, үндэс угсаа, хот/хөдөөгийн харьяалал, хөгжлийн бэрхшээлийн төрөл, нийгэм-эдийн засгийн байдал зэрэг үзүүлэлтээр нарийвчлан ангилагдсан байх ёстой. Мөн улс орнууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, **Вашингтоны Хөгжлийн бэрхшээлийн статистикийн бүлгийн аргачлалыг** ашиглан Конвенцийг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх системийг бий болгох шаардлагатай. Үүнээс гадна хандлага, ойлголтын талаарх мэдээлэл авах, мөн Вашингтоны бүлгийн орхигдуулсан зорилтот бүлгүүдийг хамруулах нэмэлт өгөгдөл цуглуулах арга хэрэгслийг хэрэгжүүлэх ёстой.
92. Олон улсын хамтын ажиллагааны талаар шийдвэр гаргах, хэрэгжүүлэх үед (32 дугаар зүйл) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөөллийн байгууллагуудаар дамжуулан тэдний ойр дотно түншлэл, хамтын ажиллагаа, оролцоо нь Конвенцийн дагуу хөгжлийн бодлого боловсруулахад нэн чухал ач холбогдолтой. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудтай зөвлөлдөж, тэднийг хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн боловсруулалт, хэрэгжилт, хяналт-шинжилгээний бүх шатанд оролцуулах ёстой. Үүнд 2030 он хүртэлх

Тогтвортой хөгжлийн хөтөлбөр болон **2015–2030 оны Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн хүрээ баримт бичиг** орно.

93. Хорооны гишүүнчлэлийн холбогдох шалгуурыг хүндэтгэхэд Конвенцийн 34 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг чухал үүрэгтэй. Энэ нь Улс орнууд нэр дэвшигчийг томилохдоо Конвенцийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан үүргийг сайтар харгалзан үзэхийг шаарддаг. Иймд Улс орнууд нэр дэвшигчдээ томилохын өмнө хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудтай нягт зөвлөлдөж, идэвхтэйгээр оролцуулах ёстой. Үүний тулд ил тод, оролцоонд суурилсан журмыг баталгаажуулах үндэсний хууль тогтоомж, журмыг бий болгож, зөвлөлдөх үйл явцын үр дүнг тооцон авч үзэж, эцсийн нэр дэвшүүлэлтэд тусгах шаардлагатай.

У. ҮНДЭСНИЙ ТҮВШИНД ХЭРЭГЖИЛТ

94. Хороо нь Гишүүн улсуудын тус Конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдох хууль тогтоомж, бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих үйл явцад тэднийг зөвлөлдөж, оролцуулах эрхийг хангахад тулгарч буй бэрхшээл, сорилтуудыг хүлээн зөвшөөрч байна. Иймд Гишүүн улсууд 4 дүгээр зүйлийн 3 болон 33 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг бүрэн хэрэгжүүлэхийн тулд, бусад арга хэмжээнээс гадна, дараах арга хэмжээг авах ёстой.

- (a) Хуулийн чадамжийг үгүйсгэсэн болон бусад бүх төрлийн хуулийг хүчингүй болгож, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээс үл хамааран бүх хүнийг өөрсдийн байгууллагаараа дамжуулан нягт зөвлөлдөж, идэвхтэй оролцох боломжийг хаахгүй байх;
- (b) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага байгуулагдаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх бодлогын орчныг бүрдүүлэх. Үүнд тэдгээрийн төрөөс хараат бус байдал, бие даасан байдлыг баталгаажуулах, нийтийн болон олон улсын хамтын ажиллагааны санхүүжилтийн зохицуулалт бий болгох, хэрэгжүүлэх, санхүүжилтэд нэвтрэх боломжийг хангах, чадавхжуулах техникийн туслалцаа үзүүлэх зэрэг багтана;
- (c) Үндэсний болон олон улсын түвшинд Конвенцоор олгогдсон эрхээ хамгаалан ажиллаж буй хувь хүн, байгууллагуудыг сүрдүүлэх, дарамтлах, өш хонзонгоор хандах үйлдлийг бүрэн хориглох. Мөн Хороотой болон бусад олон улсын байгууллага, хүний эрхийн механизмуудтай хамтран ажиллаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний төлөөллийн байгууллагуудыг хамгаалах тусгай механизмыг бий болгож хэрэгжүүлэх;

- (d) Гишүүдийн үйл ажиллагааг зохицуулж, төлөөлөн оролцуулах чадвартай нэгдсэн холбооны байгууллагууд болон төрөл бүрийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагыг дэмжиж, хамгийн бага төлөөлөлтэй бүлгүүдийг ч хамруулан хяналт-шинжилгээний үйл явцад бүрэн оролцуулах; хэрэв бүх байгууллагыг оролцуулах боломжгүй тохиолдолд байнгын болон түр ажлын хэсэгт тэдгээрийн төлөөллийг багтаах;
- (e) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудын оролцох эрхийг хүлээн зөвшөөрсөн хууль, бодлого баталж, бүх шатны байгууллага, шийдвэр гаргах түвшинд зөвлөлдөх тодорхой журам тогтоох. Энэ хүрээнд олон нийтийн сонсголыг шийдвэр гаргахаас өмнө заавал зохион байгуулах, тодорхой хугацааны хуваарь, хүртээмжтэй зөвлөлдөх журам, шаардлагатай бол үндэслэлтэй тохируулга, дэмжлэг үзүүлэх үүргийг хууль, журмаар тодорхой заах;
- (f) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудтай тогтмол зөвлөлдөх тогтолцоог бий болгож, дугуй ширээний уулзалт, оролцооны хэлэлцүүлэг, олон нийтийн сонсгол, судалгаа, цахим зөвлөлдөх хэлбэрийг ашиглах. Үүнд үндэсний зөвлөх хороо буюу хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөөллийн үндэсний зөвлөл байж болно;
- (g) Төрөлхийн болон эрүүл мэндийн байдал, нас, хүйс, хэл, үндэс, угсаа, уугуул эсхүл нийгмийн гарал, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, интерсекс онцлог, шашин, улс төрийн үзэл бодол, цагаачийн байдал, бэрхшээлийн төрөл болон бусад шинжээр ялгаатай бүх хүмүүсийн төлөөллийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагаар дамжуулан оролцуулахыг баталгаажуулах;
- (h) Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидын байгууллагуудтай хамтран ажиллаж, тэднийг олон нийтийн шийдвэр гаргах бүх үйл явцад аюулгүй орчинд шууд оролцуулах. Тухайлбал, эмэгтэйчүүдийн эрх, хүйсийн тэгш байдал, жендэрт суурилсан хүчирхийлэл, тэр дундаа бэлгийн хүчирхийлэл, дарамттай холбоотой бодлогын асуудлуудад;
- (i) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэр дундаа хүүхэд, эмэгтэйчүүдийг төлөөллийн байгууллагаараа дамжуулан төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний бүх түвшинд, ялангуяа өөрсдөд нь хамаатай асуудлуудад оролцуулах. Үүнд эрсдэлтэй нөхцөл, хүмүүнлэгийн онцгой байдал ч орно. Тэдэнд санал бодлоо илэрхийлэхэд бодитой хугацаа, хангалттай санхүүжилт, дэмжлэг үзүүлэх;
- (j) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн болон тэдгээрийг дэмжигч бүлгүүд, тухайлбал эцэг эх, гэр бүлийн байгууллагуудыг үүсгэн байгуулах, чадавхжуулах, санхүүжүүлэх, үр нөлөөтэй оролцоог бүх түвшний шийдвэр гаргалтад хангах. Үүнд орон нутгийн, үндэсний,

бүс нутгийн (бүс нутгийн интеграцийн байгууллагуудын хүрээнд ч байж болно) болон олон улсын түвшин хамаарна;

- (k) 4 дүгээр зүйлийн (3) болон 33 дугаар зүйлийн (3)-ын хэрэгжилтийг тогтмол хянаж, энэ үйл явцад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудын манлайллыг хангах;
- (l) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудын оролцоотойгоор үр нөлөөтэй хэрэгжилтийн хяналтын механизм бий болгож, гишүүн улсын үүргийг биелүүлээгүй тохиолдолд утга учиртай шийтгэл, хариуцлага, эрх зүйн хамгаалалтыг хэрэгжүүлэх;
- (m) Бүх байгууламж, материал, уулзалт, санал авах уриалга, журам, мэдээлэл, харилцаа холбоог хүртээмжтэй болгож, шаардлагатай тохируулга хийх замаар нийтийн шийдвэр гаргалт, зөвлөлдөх, хяналт-шинжилгээний үйл явцад хөгжлийн бэрхшээлтэй бүх хүнийг, тухайлбал байгууллага, сэтгэцийн эмнэлэгт хоригдож буй хүмүүс, аутизмтай хүмүүсийг ч оролцуулах боломжийг хангах;
- (n) Нас, хөгжлийн онцлогт нь нийцсэн дэмжлэгийг олгож, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн оролцоог хүүхдэд ээлтэй, хүртээмжтэй, ил тод, эрхэд суурилсан арга хэлбэрээр хангах стратеги боловсруулах;
- (o) Зөвлөлдөх, оролцуулах бүх үйл явцыг ил тод, ойлгомжтой хэлбэрээр, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүх байгууллагад хүртээмжтэй байлгах;
- (p) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд үндэсний болон олон улсын эх үүсвэрээс, тухайлбал хувь хүн, компани, ТББ, гишүүн улс, олон улсын байгууллагаас санхүүжилт, бусад нөөцийг чөлөөтэй авах боломжийг баталгаажуулах. Үүнд татварын хөнгөлөлт, үндэсний сугалааны санхүүжилт ч хамаарна;
- (q) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудыг оролцуулан хөгжлийн бэрхшээлтэйд хамааралгүй хууль тогтоомжийн хүрээ дэх одоо байгаа зөвлөлдөх үйл явцыг хүртээмжтэй, хамруулах;
- (r) Олон нийтийн төсвийн үйл явц, Тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн хяналт, олон улсын шийдвэр гаргалт, хамтын ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудтай нягт зөвлөлдөж, тэдний эрх, үзэл бодлыг тусгасан хөгжлийн бодлогыг 2030 он хүртэлх хөтөлбөрийн үндэсний хэрэгжилтэд уялдуулах;
- (s) Бүх шатны төрийн байгууллагын хариуцсан цэг, зохицуулалтын механизмд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог баталгаажуулж, хараат бус хяналтын хүрээнд тэдний төлөөллийг

хангах;

- (t) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудыг бүс нутгийн болон дэлхийн түвшний хүний эрхийн механизмд идэвхтэй оролцуулах, оролцоог дэмжих;
- (u) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудтай нягт зөвлөлдөж, сайн оролцоог тодорхойлох шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх тодорхой хугацаа, хариуцах этгээдийг тодорхойлох. Энэ оролцоог хэмжихийн тулд жишээлбэл хуульд оруулах өөрчлөлтийн саналд тэдний оролцооны цар хүрээг тайлбарлах, эсвэл шийдвэр гаргах үйл явцад хэдэн төлөөлөгч оролцсон талаар тайлагнах боломжтой.

